



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№172 /382/

2022.09.27

Цаг үе, үйл явдал

## САЛБАР ЗӨВЛӨЛИЙН III ХУРАЛ БОЛОВ



Өнөөдөр ЗХЖШ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн III хуралдаан Даргын зөвлөлийн хурлын танхимд боллоо.

Уг салбар зөвлөлийн хуралд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, Гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн дарга бригадын генерал С.Ганбямба болон салбар зөвлөлийн гишүүд, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагын салбар зөвлөлийн дарга нар оролцов. ЗХЖШ-ын зохион байгуулалтын

бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлалууд, Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын салбар зөвлөлүүдийн 2022 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, санал солилцсон юм. Хурлын төгсгөлд Салбар зөвлөлийн дарга бригадын

генерал С.Ганбямба салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаа, осол хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар нийт бие бүрэлдэхүүнд үүрэг чиглэл өглөө.

## 32 СУРГАГЧ БАГШ 8 ДУГААР ЗЭРГИЙН БОЛЗОЛ ХАНГАЛАА



Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын гардан тулааны сургагч багш бэлтгэх Шинкиокушинкай каратэгийн нэгдүгээр шатны сургалт бэлтгэлийг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү сургалтад хамрагдсан гардан тулааны 32 сургагч багш шалгалтад хамрагдан 8 дугаар кю, цэнхэр бүсний болзол хангалаа.

Хоёрдугаар шатны сургалт бэлтгэл тулааны хичээлээр үргэлжилж байна. Киокушинкай каратэгийн бэлтгэл сургалт

нь үе шат ахих тусам ачаалал нэмэгдэж, суралцагчаас ур чадвар, тэсвэр тэвчээр шаарддаг.

Анги, байгууллагаасаа сонгон шалгаруулалтаар тэнцэж уг сургалтад хамрагдаж байгаа дайчин эрс идэвх зүтгэл, сэтгэл зүйн өндөр түвшинд бэлтгэгдэж байна.

**Монголын Шинкиокушинкай каратэгийн холбооны салбар "Арми" клубын багш П.ДАРХАНБААТАР**

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 21	☁️ 3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	☁️ 21

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.475.00	3.490.0
EUR 🇪🇺	3.415.0	3.440.0
CNY 🇨🇳	479.00	482.00
RUB 🇷🇺	52.70	53
JPY 🇯🇵	24.50	25
KRW 🇰🇷	2.47	2.50

### ЗУРХАЙ

2022.09.27 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 2

**НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Үс засуулбал:**

Хэл, ам хэрүүл тэмцэл ирнэ.

**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**

06.45-19.41

**Барилдлага:**

Хүчин төгсөх

**Шүтэн барилдлага:**

САНСАР

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн.

Хол газар яваар одогсод зүүн хойшоо мөрөө гаргавал зохистой.



**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 620,640,348

Эдгэрсэн

Нийт: 600,904,485

Нас барсан

Нийт: 6,541,519



# “АЛДАР”-ЫНХАН ИЛҮҮРХЭВ



Төв аймгийн Зуунмод хотноо Дугуйт цанын улсын аварга шалгаруулах тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээний эхний өдөр хошууч Х.Хаш-Эрдэнэ дасгалжуулагчтай “Алдар” спорт хорооны баг тамирчдаас эрэгтэй 15км-т О.Золбаяр мөнгө, эмэгтэй 10км-т Э.Ариунтунгалаг алт, Т.Ариунболд мөнгө, Б.Номин-Эрдэнэ хүрэл медаль хүртлээ.

Тэмцээний хоёр дахь өдөр эрэгтэй 10км-т О.Золбаяр мөнгө, эмэгтэй 5км-т Э.Ариунтунгалаг алт, Б.Ариунболд мөнгө, А.Энхтуул хүрэл медаль хүртсэн бол сүүлийн өдөр эрэгтэй буухиа мөнгө, эмэгтэй буухиа нэгдүгээр баг алт, хоёрдугаар баг хүрэл медаль тус тус хүртэж, байгууллагын дүнгээр “Алдар” спорт хороо тэргүүн байр эзэллээ.

# ГАР БӨМБӨГ, ХӨЛ БӨМБӨГ, ТУУХАЙ ӨРГӨЛТИЙН АВАРГУУД ТОДРОВ



Зэвсэгт хүчний 2022 оны аварга шалгаруулах тэмцээн амжилттай үргэлжилж байна. Тэмцээнд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн 30 гаруй багийн 1200 тамирчин хөл бөмбөг, сагсан бөмбөг, гар бөмбөг, рагби, туухай өргөлт гэсэн таван төрлөөр 9 дүгээр сарын 19-29-ний өдрүүдэд өрсөлдөж байгаа бөгөөд зарим төрлийн аваргууд тодорсоор байна.

Хөл бөмбөгийн тэмцээнд 24 баг хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс Зэвсэгт хүчний 310, 337, 032 дугаар ангийн тамирчин дайчид манлайлсан бол гар бөмбөгийн тэмцээний эрэгтэйчүүдийн төрөлд 32 баг өрсөлдөж Зэвсэгт хүчний 029, 327, 325 дугаар ангийн баг тамирчид тэргүүлэв.

Эмэгтэйчүүдийн төрөлд 22 баг өрсөлдөж Зэвсэгт хүчний 065, 353, 029 дүгээр ангийнхан эхний гурван байрт шалгараад байна. Харин туухай өргөлтийн эрэгтэйчүүдийн төрөлд 60, 65, 70, 75, 80, 85 кг гэсэн таван жинд өрсөлдөхөд багийн дүнгээр Зэвсэгт хүчний 150, 350, 029 дүгээр анги, эмэгтэйчүүдийн төрөлд 60, 70 кг жинд багийн дүнгээр Зэвсэгт хүчний 065, 189, 350 дугаар ангийн тамирчид манлайллаа.

Тэмцээн өнөөдөр сагсан бөмбөгөөр үргэлжилж байгаа бөгөөд хаалтын ёслол 9 дүгээр сарын 29-ний өдөр Төв цэнгэлдэх хүрээлэнд болж, аваргууддаа шагнал гардуулна.



# ДУРСАМЖ ДҮҮРЭН НЭГЭН ӨДРИЙГ ӨНГӨРҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 065 дугаар анги алба сурталчлах аяныг өнгөрсөн долоо хоногийн турш амжилттай зохион байгуулав.

Аяны хүрээнд Тоон систем автоматжуулалтын албаны бүрэлдэхүүн шинээр сагсан бөмбөгийн инженер техник электрон онооны самбар хийж ангидаа дурсгаж,

тайзны гэрэл болон утаа гаргагчийг засварлаж бүрэн ажиллагаатай болгон Сургалт, соёл хүмүүжлийн албандаа хүлээлгэн өгчээ.

Мөн “Яг түүн шиг” цэнгээнт тэмцээнийг алба хаагчдын дунд зохион байгуулж, тэргүүн байрт инженер техник албаны дэслэгч Э.Санчир, дэд байрт Зэвсэг техник

химийн албаны ахлах ахлагч Д.Баярхүү нар тодорчээ.

Тус аяны талаар ахлах ахлагч Д.Баярхүү “Цар тахлаас улбаалан урлаг соёлын болон олон нийтийг хамарсан ажлууд түр зогссон байсан цаг үе ард хоцорч манай анги байгууллага хамт олны сэтгэлийг

сэргээсэн, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, манлайллыг нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээнүүд төлөвлөн зохион байгуулсаар байна. Хамт олонтойгоо нэгэн сайхан дурсамжит өдрийг өнгөрүүлээ” хэмээн сэтгэгдлээ хуваалцлаа.

Ахмад Л.САРАНЗАЯА

# ТУСГАЙ ТОГЛОЛТОО ТОЛИЛУУЛЖ БАЙНА



Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгаас Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд залуу нас, хөдөлмөр зүтгэлээ зориулсан ахмадууддаа зориулсан тусгай тоглолтыг хүргэж байна.

Тухайлбал, саяхан зохион байгуулсан БХЯ-ны Ахмадын хорооны 2022 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлангийн хурал болон ахмадууддаа хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагаанд үндэсний урлагийн, мөн цэргийн сэдэвт урын сангийн бүтээүүд болон энэ онд улсын болон олон улсын уралдаанаас шагнал хүртсэн шилдэг бүтээлүүдийн дээжсээ сонирхуулсан юм.

# АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Олон улсын Ахмадын баярыг тохиолдуулан Зэвсэгт хүчний 032 дугаар анги ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлээ. Хүндэтгэлийн үйл ажиллагаанд ангийн нийт бие бүрэлдэхүүн, ахмад дайчдын төлөөлөл оролцов.

Ангийн захирагч хурандаа М.Болдбаатар хэлсэн үгэндээ “Өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хэлхээс болж, ахмад, дунд, залуу үеийнхний холбоо харилцааг бэхжүүлэх явдал нь бидний зайлшгүй хэрэгжүүлэх ёстой үүрэг. Ахмад дайчид та бүхний гавьяа зүтгэлийг үеийн үед дурсан санаж, хойч үедээ таниулан, сурталчлах болно” гэж онцоллоо.

Хүрэлцэн ирсэн ахмад дайчдаас Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медалиар 1, Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүндэт медалиар 12, “Багабаян” амралтын газар амрах эрхийн бичгээр 5 ахмадыг тус тус шагнаж урамшуулсан нь баяр дээр баяр нэмсэн явдал болов. Ахмад дайчид хурандаа генерал Ж.Ёндонгийн хөшөөнд цэцэг өргөн хүндэтгэл үзүүлж, дурсгалын зураг татуулсан юм.

Ахмад Т.ДЭЛГЭРМАА

# ОЛОН УЛСЫН ЭНХ ТАЙВНЫ ӨДРИЙН ЭРГЭН ТОЙРОНД



Өмнөд Судан дахь НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид “Олон улсын энх тайвны өдөр”-ийг тохиолдуулан орон нутгийн иргэдийн дунд олон арга хэмжээ зохион байгуулсны дотор нутгийн 30 залууг сонгон авч, 6 долоо хоногийн хугацаатай үнэ төлбөргүй мэргэжлийн сургалтад хамруулж, шаардлагатай үр чадварыг эзэмшүүлжээ.